



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар A/06

Зуунмод

Газрыг үнээр нь өмчлүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.1.6, 29.2, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын Номт 1-р баг, Цэлмэг хотхон 612 тоот, 4110061556 нэгж талбарын дугаартай 300 м<sup>2</sup> гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг иргэн Гомбожав овогтой Ринчинханд /НИО43080661/-д суурь үнэ 1.200.000 /Нэг сая хоёр зуун мянган/ төгрөгийн үнээр нь өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгч иргэн А.Ичинхорлоод дараах үүргийг хариуцуулсугай.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн:

19.2.1. Кадастрын зураглалын ба газрын кадастрын тухай хуульд заасны дагуу газрын улсын бүртгэлийн кадастрын зураг хийлгүүлэх;

19.2.2. Өмчлөлийн газрынхаа заагийг газар дээр тэмдэгжүүлүүлэх;

19.2.3. Өмчилж авах газартаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгүүлэх;

19.2.4. Газар өмчилж авахтай холбогдсон энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Улсын бүртгэлийн хэлтэс /Н.Энхбат/-т дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1. Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

ЗАСАГ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

010225